

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

Доктор Д.Ундрах:

Миний хувьд ХХ зуунаар судалгаа хийдэггүй. Сонирхолтой сайхан илтгэл хэлэлцүүлсэн танд баяр хүргэе. Хятад ажилчдын клубийн үйл ажиллагааны хүрээ, дотоод дүрэм журмын талаар дэлгэрэнгүй ярилаа. Гол дэвшүүлж буй санаа нь Хятад ажилчдын клуб байгуулагдахаас өмнө 1900-1930 оны хооронд байгуулагдсан Ший-Яньз нь энэхүү клубын үндэс суурь болжээ гэж дүгнэжээ. Миний нагац нар 1 дүгээр дэлгүүрээс Гэсэр сүм хүртэл Ший-Яньз байсан тэнд очиж хоол иддэг, нагац өвөө маань оройн курсээр хятад хэл сурч байсан тухай ярьдаг байсан. Ший-Яньзад ший жүжиг, сүүдэр ший тоглодог, жүжигчид нь өдөртөө тогооч, цэвэрлэгч хийж байгаад орой нь жүжгээ тоглодог байсан гэж ярьж байсан. Одоо харахад Хятад ажилчдын клуб бий болсноороо үйл ажиллагаа нь зөвхөн хятад ажилчдадаа зориулсан байжээ. 1960-аад оноос хойш эдгээр Ший-Яньз, хятад гуанзнууд байхгүй болсон ажээ.

Та дүгнэлтдээ 1990-ээд онд Монгол-Хятадын соёлын харилцаа дахин сэргэхэд Ший-Яньзийн үлдээсэн хувь нэмэр байсан хэмээснээс тань би өөр саналтай байсан юм. Яагаад гэвэл, 1990-ээд он гэхэд Хятадын соёлын нөлөө тэр чигээрээ арчигдсан. Хятадтай холбоотой бүх зүйлийг хорьсон байв. 1940, 1950-аад оны хүмүүст хятад соёлтой холбогдох бага зэргийн юм үлдсэн байж магадгүй байв. Энэ үед зөвхөн Зөвлөлтийн соёлын нөлөө байсан учраас буцаж сэргэсэн нь Ший-Яньзаас үлдээсэн өв байсан гэдэгт эргэлзэхэд хүргэж байна. Та яагаад энэ дүгнэлтэд хүрсэн бэ гэдэг асуулт байна?

Таны илтгэлийн хувьд Нэгдүгээрт, архивын баримт ихтэй сайн илтгэл болжээ. Хоёрдугаарт, Хятад ажилчдын клубуудийн үйл ажиллагаа хумигдсан талаар тодорхой хэлж өглөө. Мөн монголчуудад зориулаагүй, зөвхөн хятад иргэдэд зориулсан үйл ажиллагааг явуулдаг байсан нь судлууштай судалгааны сэдэв байна гэж харлаа.

Өмнөх үеийн 1950-иад оны шүлгийн түүвэр дотор Д.Сэнгээгийн «Тогооч» гэдэг найраглалд монгол хүний төлөө амиа зориулж буй хятад хүний тухай өгүүлэмж гардаг. Мөн «Ардын элч» кинонд сайхан сэтгэлт хоёр хятад хүний тухай өгүүлэмж гардаг. Ийм үзэгдэл өгүүлэмж 1960, 1970 оны үед байхгүй болсон нь хоёр орны харилцаатай л холбоотой. 1990-ээд он гэхэд Хятадын соёлын тухай, хятад хүний дүр байхгүй болж монголчууд бид Хятадтай огт харьцаж байгаагүй мэт ой санамжаас арчигдсан байсан. Сүүлд аажмаар бага багаар Монгол дахь хятад соёлын тухай, хятад ажилчдын клубуудийн тухайд анхаарч эхлээд байна.

Хариулт: Судлаач Ц.Түмэнбаяр:

1966 онд хаагдсан «Хятад ажилчдын клуб»-ийн үйл ажиллагаа 1990 онд Монгол Хятадын соёлын харилцаа сэргэхэд чухал нөлөө үзүүлсэн. Учир нь хэрэв тухайн үед ажилчдын клуб байгаагүй бол өнөөдөр бид Монгол-Хятадын хамтын ажиллагаа өмнө нь ийм байсан тухайд сэргээж ярьж чадахгүй юм. Тэгэхээр энэ нь тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлсэн гэж үзэж байна. БНМАУ аль эрт 1920-иод онд тусгаар тогтнолоо тунхагласан, харин Хятад бол улс төрийн хувьд тогтворгүй, дотроо хагаралтай явсаар 1949 оныг хүргэж байж сая БНХАУ-ыг тунхагласан. Чан Кайшигийн засгийн газартай манайх бараг л харилцаагүй шүү дээ. Ийм үед Монголд байсан хятад иргэдийг соён гэгээрүүлэх, тэднийг ажил хөдөлмөрөөр хангах, үр хүүхдийг нь сургах хүмүүжүүлэх, бичиг үсэгтэй болгох, оюуны хэрэгцээг нь хангах зэргээр манайх идэвхтэй ажилласан юм шүү. Монголын төр, ард түмэн мөнхийн хөрш болох Хятадын ард түмэнд чин сэтгэлээсээ хандаж, тусалж байж. Энэ нь эргээд манай хоёр орны эдийн засаг, соёлын харилцаа сэргэхэд эерэг нөлөө үзүүлсэн.

Асуулт: доктор Sc.D, профессор Ж.Урангуа:

Баярлалаа. Би хоёр асуулт асууя. Нэгдүгээрт, 1951 онд Монгол дахь «Хятадын харьяатуудын нийгэмлэг» гэж байгуулаад, түүний дэргэд «Хятад ажилчдын клуб», «Ажилчны зам» сониныг Хятадын тал манайд шилжүүлсэн байдаг. Яагаад шилжүүлэх болов? Мөн 1959 онд буцаагаад авсан. Ямар учир шалтгаантай байсан юм бол? Та үүнийг юу гэж үздэг вэ? Хоёрдугаарт, Монголын тал «Үй-цай» сургууль болон «Найрамдал» эмнэлгийг хүлээж авахгүй гэж татгалзаж байсны шалтгаан юунд оршиж байв?

Хариулт: Судлаач Ц.Түмэнбаяр:

Өгчихөөд буцаагаад авсан тал дээр би ч бас их гайхдаг. Хятадын харьяат нарын зөвлөл гэж байсан, мөн Үйлдвэрчний байгууллага дээр Хятадын харьяат нарыг хариуцсан тасаг гэж бас байлаа. Хятадын харьяат нарын зөвлөлтэй хамтран хятад ажилчид олноороо суурьшсан газарт тэдний өөрсдийнх нь хөрөнгөөр мөн урьд худалдаачдаас хурааж авсан хөрөнгөөр Хятадын соёлын клубуудыг ажиллуулж байсан юм. Ийм шалтгаанаас л Хятадын харьяат нарын зөвлөлд өгсөн. Харин 1959 онд Хятад ажилчид олноор ирж Монгол орны бүтээн байгуулалтад оролцож эхэлсэн учраас Ший-яньзюг авсан гэж ойлгосон. Тэгэхээр өнөөдрийн илтгэлээр ерөнхийд нь танилцуулсан юм. Энэ мэтээр Монголын зүгээс гадаадын харьяат нарт хандах хандлага, явуулж байсан бодлогын талаар цаашид нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй. Хоёр дахь асуултын талаар судлаагүй юм байна.

Асуулт: доктор Ph.D Д.Наранжаргал:

Элчин сайд Заяат Монголд элчин сайдаар ирэхээсээ өмнө Ший-Яньзюд 10 жил найруулагчаар ажиллаж байсан гэдэг. Энэ талаар танд судалгаа бий юу?

Хариулт: Судлаач Ц.Түмэнбаяр:

Би тэр талаар судлаагүй. Өмнөх асуудлыг ярих гэхээр болох болохгүй, хэлэх хэлэхгүй зовлонтой зүйлс их гардаг. Ший-яньз анхнаасаа гамингуудыг орж ирэхэд үйлчилж байсан гэх мэтчилэн хэцүү зүйлсийг ярих болдог. Иймээс тэр талаар хөндөж яриад байдаггүй. Олон улсын чанартай хурал дээр энэ мэт сөрөг талыг ярих зохимжгүй гэж бодогдоод байдаг юм. Заяат элчин сайд болоод, дараа нь хэлмэгдсэн гэх мэт зүйлсийг аман яриагаар сонсож л байсан юм.